



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/115

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйл 30.2, 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалтууд, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Хөдөө аж ахуйн-2-200 тоот) байршилтай 288 м.кв (0,02га) орон сууцны зориулалттай газрын эзэмшигч иргэн Ягаанбандийн Нацагдорж (ЗЮ:67112211) нь 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр нас барсан тул хүү Нацагдоржийн Ууганбаяр (ЗП:89082136)-т зориулалтаар шилжүүлж 20 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/210 дугаар захирамжийн иргэн Я.Нацагдорж-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025438 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100277